



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/168


Эрдэнэт

Тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн Засаг даргын нэрэмжит Таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион явуулахад 6000000 төгрөгийн, Хүчний гурван төрөлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион явуулахад 1000000 төгрөгийн, 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Индонез улсад болох хүчний гурван төрөлтийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаа төлөөлөн оролцох Д.Баттогтоход 1000000 төгрөгийн, 2017 оны 04 дүгээр сарын 21-нээс 29-ний өдрүүдэд Шинэ Зеланд улсын Окланд хотноо зохион байгуулагдах хөнгөн атлетикийн ахмадын дэлхийн тоглолтонд Орхон аймгаа төлөөлөн оролцох Ч.Тэрбишид 500000 төгрөгийн, 2017 оны 04 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд ОХУ-д зохион байгуулагдах "Байкал 2017" гүйлтийн цанын олон улсын тэмцээнд оролцох П.Энхтүвшинд 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 9500000 /Есөн сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc
02000 0839